# НЭВТРЭЛТИЙН НЭГДСЭН СИСТЕМ

(Гарын авлага)

**УЛААНБААТАР ХОТ**
**2024 ОН**

# АГУУЛГА


СИСТЕМИЙН ХЭРЭГЛЭЭ: .... 3

Нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгүүлэх.... 4

Нэвтрэлтийн нэгдсэн системд нэвтрэх.... 6

Нууц үг сэргээх.... 8

Бүртгэлтэй утасны дугаар солих .... 10

Бүртгэл цэс ашиглан системд тохиргоо хийх заавар .... 13

Цахим шуудан шинэчлэх .... 13

Бүртгэлтэй утасны дугаар солих .... 15

Нууц үг солих.... 15

Нэг удаагийн нууц үг /OTP/ .... 17

Нэвтэрсэн төхөөрөмжүүд .... 19

Нууц үгийн аюулгүй байдал .... 20

# СИСТЕМИЙН ХЭРЭГЛЭЭ:

Нэвтрэлтийн нэгдсэн систем гэдэг нь: Хэрэглэгч нэг бүртгэлийн эрхээр олон систем рүү хандах боломжтой олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Identity and Access систем юм.

Нэвтрэлтийн нэгдсэн систем нь дараах давуу талуудтай.

- Цахим үйлчилгээг хангасан технологи
- Нэг удаагийн нууц үгийг давхар ашиглах боломж /OTP/
- Нэг нэвтрэлтээр олон систем рүү зэрэг хандах
- Цахим аюулгүй байдлын шаардлагыг хангасан
- Эрхийн тохиргоо үүсгэх, удирдах
- Системийн ачааллыг хуваарилах технологи
- Мэдэгдлийг нэгдсэн байдлаар түгээх
- Тоон мэдээлэл, судалгаа нь үнэн зөвийг хангасан
- Ойлгомжтой, хурдан хялбаршуулсан технологи

Нэвтрэлтийн нэгдсэн системд холбогдсон системүүд:

- Цахим татварын систем - https://etax.mta.mn/
- Санхүүгийн цахим систем - https://finance.gov.mn/
- Халамжийн нэгдсэн систем - https://st.ehalamj.mn/
- Санхүүгийн тайлангийн систем - https://ebalance.mof.gov.mn/
- Цалингийн нэгдсэн систем - https://payroll.gov.mn/
- Бараа бүртгэлийн нэгдсэн систем - https://data.ebarimt.mn/
- Цахим төлбөрийн баримтын систем https://e-invoice.ebarimt.mn/
- Төрийн сангийн гүйлгээний систем - https://transaction.mof.gov.mn/
- Хяналт шинжилгээ үнэлгээний систем - https://lm3.mof.gov.mn/
- Эрүүл мэндийн даатгалын нэгдсэн систем - https://health.gov.mn/
- Тусгай зөвшөөрлийн нэгдсэн систем - https://license.mn/
- Шилэн дансны нэгдсэн систем - https://gap.mof.gov.mn/
- Вакцины нэгдсэн систем - http://Vis.health.gov.mn
- Пос апи - Operator.ebarimt.mn

## Нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгүүлэх

**АЛХАМ – 1:** Хэрвээ та “Нэвтрэлтийн нэгдсэн систем”-д бүртгэлгүй бол **БҮРТГҮҮЛЭХ** товч дарна уу.




/Зураг №1/

**АЛХАМ– 2:** Гарч ирсэн бүртгүүлэх цонхонд өөрийн мэдээллээ үнэн зөв оруулж үйлчилгээний нөхцөлтэй танилцаж зөвшөөрсний дараа **БҮРТГҮҮЛЭХ** товч дарна. Талбаруудын тайлбарыг ногооноор тэмдэглэсэн хэсгээс харж болно.




/Зураг №2/

**АНХААРАХ:** Нууц үгээ дараах шаардлагын дагуу оруулахыг анхаарна уу.




/Зураг №3/

**АЛХАМ– 3:** Таны бүртгүүлсэн цахим хаягаар баталгаажуулах шуудан илгээсэн очно.




/Зураг №4/

**АЛХАМ– 4:** Цахим шуудtarg ирсэн баталгаажуулах холбоос дээр дарж цахим шуудангийн хаягийн баталгаажуулалтыг хийнэ үү.




/Зураг №5/

**АНХААРАХ:** Тухайн регистрийн дугаар буюу хэрэглэгч системд бүртгэлтэй байна гэсэн анхааруулга гарсан бол **НУУЦ ҮГ СЭРГЭЭХ** үйлдэл хийнэ үү.

## Нэвтрэлтийн нэгдсэн системд нэвтрэх

**АЛХАМ – 1:** Иргэний бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар, Цахим шуудангаар нэвтрэх боломжтой тул та дээрх утгуудын аль нэгийг нууц үгийн хамт оруулан **НЭВТРЭХ** товч дарна.




/Зураг №6/

**АЛХАМ – 2:** Таны бүртгэлтэй цахим шууданд төхөөрөмж баталгаажуулах код цахимаар илгээсэн. Та тус кодыг системд оруулж бүртгэлийг баталгаажуулах шаардлагатай. Системийн баталгаажуулалтыг цахим шуудан болон гар утасны дугаар, Ибаримт аппликейшний аль нэгээр нь хийх боломжтой.




/Зураг №7/

**АЛХАМ – 3:** Цахим шуудангаар ирсэн төхөөрөмж баталгаажуулах код /Зураг №8/ харуулсны дагуу ирнэ. Өөрийн идэвхтэй ашигладаг төхөөрөмжийг баталгаажуулснаар дахин нэвтрэхэд хялбар байх болно.




/Зураг №8/

## Нууц үг сэргээх

**АЛХАМ – 1:** Нууц үг сэргээх товчийг дарна.




/Зураг №9/

**АЛХАМ – 2:** Бүртгэлтэй регистрийн дугаар эсвэл цахим шуудангийн аль нэгийг оруулан **ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ** товч дарна.




/Зураг №10/

**АЛХАМ – 3:** Утасны дугаараар баталгаажуулахыг сонгосон бол /Зураг №11/ -д үзүүлсний дагуу тусгай дугаар болох 131315 руу системд гарч ирсэн кодыг илгээсний дараа **ШАЛГАХ** товч дарна.




/Зураг №11/

**АНХААРАХ:** Системд гарч ирсэн кодыг тусгай дугаар луу 5 минутын дотор илгээнэ үү.

**АЛХАМ – 4:** Утасны дугаарыг баталгаажуулсны дараа Шинэчлэх нууц үгээ оруулан **ХАДГАЛАХ** товч дарна.




/Зураг №12/

**АНХААРАХ:** Нууц үгээ дараах шаардлагын дагуу оруулахыг анхаарна уу.




/Зураг №13/

## Бүртгэлтэй утасны дугаар солих

**АЛХАМ – 1:** Нууц үг сэргээх товч дарна.




/Зураг №14/

**АЛХАМ – 2**: Бүртгэлтэй регистрийн дугаар эсвэл цахим шуудангийн аль нэгийг оруулан **ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ** товч дарна.




/Зураг №15/

**АЛХАМ – 3:** Утасны дугаар солих үйлдлийг сонгосон бол утасны дугаар талбарт солих утасны дугаар оруулан **Хадгалах** товч дарна уу. Солих утасны дугаар таны нэр дээр бүртгэлтэй дугаар байхыг анхаарна уу.




/Зураг №16/

**АЛХАМ – 4:** Утасны дугаараар баталгаажуулахыг сонгож доорх зааврын дагуу мессеж илгээсний дараа **ШАЛГАХ** товч дарна.




/Зураг №17/

**АЛХАМ – 5:** Утасны дугаар амжилттай баталгаажуулсан тул нууц үг шинэчлэх хэсгийг харуулна




/Зураг №18/

## Бүртгэл цэс ашиглан системд тохиргоо хийх заавар

### Цахим шуудан шинэчлэх

**АЛХАМ – 1:** Хувийн мэдээлэл цэсийн “**ЦАХИМ ШУУДАН ШИНЭЧЛЭХ”** товчийг дарна.




/Зураг №19/

**АЛХАМ – 2:** Шинэчлэх гэж буй цахим шуудангаа оруулан **ХАДГАЛАХ** товч дарна.




/Зураг №20/

**АЛХАМ – 3:** Таны оруулсан цахим шууданд баталгаажуулах холбоос илгээнэ. /Зураг №22/ Тус холбоос дээр дарж баталгаажуулах үйлдэл хийснээр таны цахим шуудангийн мэдээлэл шинэчлэгдэнэ.




/Зураг №21/




/Зураг №22/

## Бүртгэлтэй утасны дугаар солих

**АЛХАМ – 1:** Хувийн мэдээлэл цэсийн “Утасны дугаар” талбарт өөрийн нэр дээрх бүртгэлтэй утасны дугаарыг оруулан **ХАДГАЛАХ** товчийг дарна.




/Зураг №23/

АНХААРАХ: Өөрийн нэр дээр бүртгүүлсэн утасны дугаарыг оруулах шаардлагатай.

## Нууц үг солих

**АЛХАМ – 1:** Нууцлалын тохиргоо цэсийн **НУУЦ ҮГ СОЛИХ** товчийг дарна.




/Зураг №24/

**АЛХАМ – 2:** Шинэ нууц үгээ оруулан **ХАДГАЛАХ** товчийг дарна.




/Зураг №25/

**АНХААРАХ:** Нууц үгээ дараах шаардлагын дагуу оруулахыг анхаарна уу.




/Зураг №26/

**АЛХАМ – 3: Таны** нууц үг шинэчлэгдлээ гэсэн мэдэгдлийг цахим шуудангаар илгээнэ.




/Зураг №27/

## Нэг удаагийн нууц үг /OTP/

**ХЭРЭГЛЭЭ**: Нэг удаагийн нууц үг нь байнгын ашиглагддаг нууц үгийг оруулсны дараа давхар баталгаажуулагч нууц үгийг нэмэлтээр тохируулах хэсэг юм. Энэхүү үйлдлийг хийснээр бүртгэлийн мэдээлэл алдагдах эрсдэл буурах давуу талтай.

**АЛХАМ – 1:** Нууцлалын тохиргоо цэсийн **ТОХИРУУЛАХ** товчийг дарна.




/Зураг №28/

**АЛХАМ – 2:** Доорх зааврын дагуу гүйцэтгэж хадгалах товч дарна.




/Зураг №29/

**АЛХАМ – 3:** Амжилттай үүссэн OTP жагсаалтад нэмэгдэж /Зураг №30/ цахим шууданд мэдэгдэл илгээнэ. **УСТГАХ** товчийг дарснаар OTP-г устгах боломжтой.




/Зураг №30/




/Зураг №31/

# Нэвтэрсэн төхөөрөмжүүд

**АЛХАМ – 1:**

Хандалтын түүх цэсээс нэвтэрсэн төхөөрөмжүүдийн мэдээллийг харах боломжтой бөгөөд **ГАРАХ** болон **БҮХ ТӨХӨӨРӨМЖӨӨС ГАРАХ** товчийг дарж холболт хийгдсэн төхөөрөмжүүдийг салгах боломжтой.




/Зураг №32/

# Нууц үгийн аюулгүй байдал

**АЛХАМ – 1:** Нууц үгээ буруу оруулахад таны бүртгэлтэй цахим шууданд /Зураг №34/ мэдэгдэл илгээнэ. Нууц үгээ 3 удаа буруу оруулахад 1 минутын хугацаатай таны эрх түгжигдэнэ. Дахин буруу оруулсан тохиолдолд дахин 1 минутын давтамжтай түгжигдэхийг анхаарна уу.




/Зураг №33/




/Зураг №34/